

24. Бурхан минь, бид Найдвар доторх эмэгтэйчүүдийг сонсдог Сенегалын эмэгтэйчүүдийн авралын төлөө залбирч байна. Тэд Христийн дагалдагч болж, нийгэмдээ эерэг хувь нэмрийг оруулах болтугай. (Ис. 12:2)

25. Аав аа, Бениний удирдагчдын зүрх сэтгэлд Та үгээ хэлээч. Бурханлаг хүмүүсийг эдгээр удирдагчид зөвлөгч, зуучлагч болгон илгээгээч. (Сур. 12:15)

26. Эзэн минь, Нигерийн баг нэмэлт орчуулга болон залбиралын хуанли тараахад зориулж үндэсний хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгож өгөх болтугай. (2 Кор. 9:8)

27. Тэнгэрлэг Аав минь ээ, Габонд ядуу амьдарч буй хүмүүсийн сүнслэг, бие махбодь, санхүүгийн болон сэтгэл санааны хэрэгцээг хангаж өгөөч хэмээн бид Танаас гуйж байна. (Дуу. 113:7)

28. Эзэн минь, Та бол эвлэрлийн Бурхан. Кот-д'Ивуар дахь эхнэрээ хаясан нөхрүүд гэртээ буцаж ирээд дахин нэгдэх болтугай. (Мал. 2:14-16)

29. Аав аа, Либерийн өсвөр үеийнхэнд бие нь Ариун Сүнсний сүм гэдгийг ойлгуулж, хар тамхи, согтууруулах ундаа хэрэглэхээс татгалзах хэрэгтэй гэдгийг ойлгуулж өгөөч. (1 Кор. 6:19-20)

30. Бениний уламжлалт зан үйл, шүтээн шүтэх айдас нь тэднийг сайн мэдээг хүлээж авах нь саад болж байна. Бурхан минь, Та сүм чуулганаар дамжуулан тэдэнд авралын авралын мэдээг хүлээж авахад туслаач. (2Тим 4:5)


Монголын төлөө залбирах сэдвүүд

1. To protect children's rights and grow up in a safe environment. For girls to grow up in a society protected from violence.

2. May God-fearing leaders emerge in the parliamentary elections in 2024, create justice and equality in the society, and let all laws be made for the sake of the people.

3. Divorce rate is increasing day by day. For young people to make the right choices in life and for children to grow up in a complete family

4. For single mothers who are struggling to support their families. May God hear their voice, be their strength, protector and comfort.



몽골 소망의 여인들 페이스북

몽골 소망의 여인들 후원 안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 11.

Баруун болон Төв Африкийн төлөөх залбирал1

Нигери дахь TWR Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэл нь 2018 онд Абиа мужид үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш нэвтрүүлэг бэлтгэж, залбирлын хуанли тараахаас гадна эргэн тойрны олон эмэгтэйчүүдэд нийгмийн үйлчлэлийг үзүүлдэг. Эмнэлэгийн үйлчилгээ, тусламж авч чадахгүй байгаа эмэгтэйчүүдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх, мөн тэдэнд гар аргаар саван, гэр ахуйн эд зүйл хийхийг зааж сурган, өөрсдийгөө болон гэр бүлээ тэжээх санхүүгийн эх үүсвэрээ олох боломжийг олгодог.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr
몽골 연락처 namulun89@gmail.com

1. Ариунаас ариун Бурхан минь, Сатан мөргөдөг тахилын ширээ, бэхлэлт, хуурамч бурхдыг устгах хүчээ Либерийн ард иргэдэд харуулаач хэмээн бид залбирч байна. (Шүүгч 6:25)

2. Аав аа, Кот-д'Ивуар дахь хүүхэдтэй болохыг хүсэн хүлээж байгаа хүүхэдгүй эмэгтэйчүүдэд Та бэлэг болох хүүхдийг өгөөч хэмээн залбирч байна. (Дуу. 113:9)

3. Аав аа, Габоны удирдагчдад эдийн засгаа сайжруулж, ажлын байр бий болгож, ард түмэн гэр бүлээ тэжээх мэргэн ухааныг өгөөч. (Сур. 2:6)

4. Эзэн минь, Нигери дэх сайн мэдээг хүлээн авах хүсэлтэй хүмүүст радио түгээгдэж, бусдад радио хамт сонсох урилгыг түгээж, тэр ч байтугай дэлгүүртээ сайн мэдээний нэвтрүүлгийг радигоор дамжуулан явуулж, сайн мэдээг түгээх болтугай. (Ром. 1:16)

5. Бурхан минь, Сенегал дахь гэр бүлүүдийг гэр бүлийн хүчирхийллээс Та хамгаалаач. (Иер. 15:21)

6. Бенин улсад орон нутгийн сүм хийдүүд болон манай хамтрагч Бениний Евангелийн Хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдсан TWR Найдвар доторх эмэгтэйчүүд багууд болон зуучлагч бүлгүүдийн төлөө Эзэн минь, Таныг магтъя. (Флп. 1:5)

7. Бурхан минь, Мали дахь Найдвар доторх эмэгтэйчүүд нэвтрүүлэгийн багийнхан сонсогчдын уулзалт хийхээр сонсогддоо урьсан тул та багийн гишүүдэд мэргэн ухааыг өгөөрэй. (2 Тим 2:2)

8. Эзэн минь, Нигери, Чад, Камерун, Нигерт гарсан дүрвэгсдийн хямралыг шийдвэрлэх бодит шийдлүүдийг өгөөч. Тэнд байгаа олон гэр бүлд өдөр тутмын энгийн хоол хүнс ч дутагдаж байна. Эзэн Та тэднийг идэх хоолоор нь хангаач. (Мат. 25:35)

9. Төв Африкийн Бүгд Найрамдах Улс алмааз, алт, газрын тос, уранаар баялаг ч ард түмэн нь ядуу амьдарч байна. Бурхан минь, засгийн газар нь ард түмэндээ эдгээр нөөцөөс ашиг хүртэх боломжийг олгох болтугай. (Дуу. 22:26)

10. Эзэн минь ээ, Сьерра-Леон улсад 15-49 насны эмэгтэйчүүдийн 90% нь бэлэг эрхтнийг зэрэмдэглэх хор хөнөөлтэй соёлын болон шашны үйлд өртсөн байна. Тэр газар соёлын өөрчлөлт бий болж, охид эмэгтэйчүүдийн бэлэг эрхтнийг Та зэрэмдэглэхээс хамгаалаарай. (Дуу. 107:6)

11. Бурхан, Нигерийн эмэгтэйчүүдийг гэр бүлээ тэжээхэд туслах саван болон гар урлалын зүйлсийг хэрхэн үйлдвэрлэх сургалтыг цаашдаа дахин идэвхжүүлэхэд туслаарай. (Сур. 14:23)



12. Аав аа, бид Танд итгэснийхээ төлөө гэр бүлээрээ хавчигдаж байгаа Габон дахь Христэд итгэгчдийн төлөө залбирч байна. Таны талд зогсох зоригийг тэдэнд өг. (1 Петр. 4:16)

13. Бурхан минь, Кот-д'Ивуарын эмэгтэйчүүд Таныг Эзэн гэдгийг ойртон таньж мэдэн, зөвхөн Танаас л авралын баяр баясгаланг олох болтугай. (1 Петр 1:8)

14. Эзэн минь ээ, Либерид дэх олон охид эмэгтэйчүүд, охид өөрсдөд нь Танас ирэх бурханлаг ханийг итгэжтэйгээр хүлээн, хүлээн авсан нь Христ итгэл дотор гэрлэж байгаагийн төлөө бид магтъя. (Дуу. 37:4)

15. Бурхан минь, Сенегал дахь манай удирдагчдад стратеги, бүтээлч сэтгэлгээг өгөөч, ингэснээр TWR

Найдвар доторх эмэгтэйчүүд үйлчлэл нь Таны нэрийг алдаршуулж, үр жимстэй бай болтугай. (Үйлс 2:47)

16. Эзэн минь, Бенин дэх Водогийн сурталчилгааг зогсоогооч. Түүний зан үйлийг дагадаг хүмүүс түүнээс татгалзаж, Есүстэй уулзаж, өөрчлөгдөх болтугай. (Үйлс 3:19)

17. Малигийн баг орон нутгийн сүмүүдтэй хамтран эмэгтэйчүүдийн хуарангаар дамжуулан сайн мэдээг дамжуулахад оролцож байгаад Бурхан Таныг магтъя. Итгэгчид Есүст итгэх итгэлээ тогтмол хуваалцах болтугай. (1 Петр. 3:15)

18. Аав аа, Камерун дахь хүн хулгайлах, хүн амины хэргийг таслан зогсоогооч. Таны оршихуй энэ үндэстэнд амар амгалан, амьдралыг авчрах болтугай. (Дэд хууль 31:6)

19. Эзэн минь ээ, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын төр шударга ёс, иргэний дайныг зогсоон амар амгаланг өгөх болтугай. Ард түмэн нь Танаас тогтвортой байдлыг олж, амрах болтугай. (Дуу. 29:11)

20. Аав аа, Нигери дэх манай TWR "Найдвар доторх эмэгтэйчүүд" багийг ашиглан бослогын улмаас гэр орон нь сүйдэж, гэр бүлийн гишүүд нь амь үрэгдсэн эмэгтэйчүүдэд үйлчлэхэд туслаарай. (2 Кор. 1:3-4)

21. Бурхан минь, Габон дахь өвчнөөр шаналж буй хүмүүсийг эдгээхийг гуйж байна. Манай TWR Найдвар доторх эмэгтэйчүүд багийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах болтугай (Иер. 17:14)

22. Аав аа, Кот-д'Ивуар дахь бэлэвсэн эхнэрүүд болон тэдний хүүхдүүдийн өв залгамжлалын эрхээ буцааж авахад нь Та туслаач. (Дуу. 68:5)

23. Аав аа, Либерийн олон эмэгтэйчүүд Таны үгийг уншиж, тантай хамт цагийг өнгөрөөж, гэр бүлийнхэнтэйгээ энэ үгийг хуваалцаж байгаад бид Таныг магтъя. (Дуу. 119:105)